## АӨСҮТ-ИЙН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

айгууллагын нэр: **АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ**

гноо: 2025-12 сар

| № | Үйл ажиллагаа | Биелэлт /Тусгах мэдээлэл/ |
|---|---|---|
| | | |
| | Хуралдаан | Огноо: 2025/01/06<br><br><u>Хэлэлцсэн асуудал:</u> Ёс зүйн дэд хорооны хурлаа хийж, 2025 онд хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэх<br><br><u>Шийдвэр:</u> 2025 оны Ёс зүйн салбар хорооны 2025 онд хийх ажлын төлөвлөгөөний талаар санал солилцон, гишүүдэд үүрэг даалгавар өгч дахин хуралдахаар шийдвэрлэсэн.<br><br>Огноо: 2025/04 сар<br><br>Хэлэлцсэн асуудал: 2025 оны 04 сард хуралдан 2024 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын ажлыг эрчимжүүлэх, 1 гишүүн ажлаас гарсан тул дахин хэнийг сонгохыг хэлцэн, ирсэн нэг гомдлыг эвлэрүүлэн зуучлагчид хуваарилан, хариу мэдэгдэх талаар хуралдсан.<br><br>Иргэд олон нийттэй харилцах төв 11-11 дугаарт 1 гомдол ирснийг тодруулан, хариу өгсөн.<br><br>Шийдвэр: Үйлчлүүлэгчээс ирсэн гомдлын дагуу тухайн гомдол гаргасан ажилчинд анхааруулга өгөн ёс зүйн сургалтанд суулгасан.<br><br>2025 оны 10 сарын 15-аас 10 сарын 21-ний өдрүүдэд **“Эрүүл мэндийн ажилтны ёс зүй”** сэдэвт сургалт, өдөрлөгийг зохион амжилттай зохион байгуулсан.<br><br>2025 оны 4 дугаар улиралд гишүүдийг шинэчлэн батлуулсан / хүний нөөцийн албаны дарга, Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга/ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Ёс зүйн сургалтад хамрагдсан хүний тоо | Эмч | Сувилагч | Эмнэлгийн мэргэжилтэн | Эмнэлгийн бус мэргэжилтэн | Резидент эмч |
| | | 110 /давтагдсан тоогоор/ | 125 /давтагдсан тоогоор/ | 38 /давтагдсан тоогоор/ | 20 | 39 /давтагдсан тоогоор/ |
| | | 332 /давтагдсан тоогоор/ | | | | |
| 3 | Ёс зүйн сургалтын сэдэв | 2025 оны 02 сарын 18-нд АШУҮИС-ийн эрдмийн сургуулийн АУ-ны эрх зүй, боловсрол судлалын тэнхимийн багш, хууль зүйн докторант Э.Ганбат хуульч-өмгөөлөгч ирж бүх ажилчдад "Эрүүл мэндийн салбарын хууль эрх зүй - Эмнэлгийн мэргэжилтний эрх зүй" сэдвээр 45 ажилтан, резидент эмч нар хамрагдсан өгөөжтэй сургалт болж өндөрлөлөө.<br> <br>2025.04.11-ний өдөр ҮЭ-ийн холбооны дарга Ч.Нарантуяа "Хөдөлмөрийн харилцаа" сэдвээр, МҮЭ-ийн холбооны Хүний эрх, хуулийн газрын дарга М.Саранцацрал “Хөдөлмөрийн эрх зүйн хэм хэмжээ” сэдвээр нийт ажилчдад 1кр сургалт зохион байгуулав. Сургалтанд 56 ажилтан, резидент эмч нар хамрагдсан. | | | | |





2025 оны 05 сарын 27-ны "Ёс суртахуун - Хандлага" сэдвээр АШУҮИС-ийн Био анагаахын их сургуулийн биологийн тэнхимийн профессор, МУ-ын ардын, гавьяат багш, доктор, профессор А.Гүрбадам сургалт хийсэн. Сургалтанд 43 ажилтан, резидент эмч нар хамрагдсан.







“Эмч, эмнэлгийн ажилтны ёс зүйн хэм хэмжээ” чиглүүлэх сургалтын 4 цагийн лекцийг Ёс зүйн хорооны дарга Б.Баярмаа 2022-2025 онд суралцаж буй резидент эмч нарт орсон.

Манай төвд суралцаж буй резидент эмч нарын багц цагийн сургалтад багтдаг ёс зүйн кредиттэй сургалтыг зохион байгуулж хичээл ордог.

**“Эрүүл мэндийн ажилтны ёс зүй, харилцаа, хандлага”**-ыг сайжруулах зорилгоор “Эрүүл мэндийн ажилтны ёс зүй” сэдвээр 2025 оны 10 сарын 15- 10 сарын 21-ний өдрүүдэд ёс зүйн өдөрлөгийг нийт албан хаагч, резидент эмч нар, хэвтэн эмчлүүлэгч, үйлчлүүлэгч нарт зохион байгуулсан.

| | | |
|---|---|---|
| | | 2025 оны 09 сарын 09-ны "Бэлгийн ёс зүйгүй үйлдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ" уулзалт хэлэлцүүлэгт Ёс зүйн дэд хороон дарга Б.Баярмаа, нийгмийн эрүүл мэндийн ажилтан Б.Хэрлэн нар оролцож санал бодлоо солилцсон.<br><br><br> |
| | | “Сувилахуйн мэргэжилтний ёс зүй хэм хэмжээ” сэдэвт сургалтанд 16 сувилагч, 3 туслах сувилагч, 4 тусгай дунд мэргэжилтэнг Ёс зүйн хорооны гишүүн ахлах сувилагч Х.Эрдэнэтуяа хамруулан сургалтыг орсон. |
| | | 2025.09.11 нд 3L Lifelong School-тай хамтран үйлчилгээний маркетер “АНГЕР МЕНЕЖМЕНТ” сэдвээр С.Энхжаргал /ангер менежментийн чиглүүлэгч/ төвийн нийт ажилчдад сургалт явууллаа. Сургалтанд нийт 38 ажилтан, албан хаагч оролцсон.<br> |
| | | Төвийн нийт эмч нар, жилийн турш 14 хоногт нэг удаа Лхагва гараг бүр мэргэжлийн болон анагаах ухааны бусад салбарын олон улсын сэтгүүлд хэвлэгдсэн шинжлэх ухааны өгүүлэл, эмнэлзүйн удирдамж, онолын мэдээлэл, практикт тохиолдсон эмнэлзүйн ховор тохиолдлын талаар танилцуулах ба оны 1 сард мэдээлэл хийх хуваарь |

гаргаж, баталсан хуваарийн дагуу ёс зүйн хорооны дарга Б.Баярмаа эмнэлгийн мэргэжилтны ёс зүй сэдвээр сургалт хийсэн.






2025 оны 10 дугаар сарын 27 өдөр /10:00 – 15:00
Хүүхдийн тасгийн ахлах сувилагч, ёс зүйн дэд хорооны гишүүн Х.Эрдэнэтуяа оролцсон.






“Мэргэжлийн ёс зүйн ач холбогдол” сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг 14 хоногийн хугацаатай зарлаж, зарласан хугацаанд 9 эссэ ирсэнээс 3 шүүгчийн дундаж оноогоор дүнг гаргалаа.
1-р бар 80,6 оноогоор Б.Лхагвасүрэн
2-р байр 75,6 оноогоор Ц.Амарзаяа
3-р байр 71,6 оноогоор М.Жанбота нар
шагналт байр эзэлсэн ба нийт оролцсон хүмүүстээ баярлалаа. Уралдаанд ирүүлсэн эссэнүүд оролцогч бүрийн үзэл бодлыг тусгасан, эмнэлгийн ажилчид бид ёс зүйтэй байх нь бие биедээ болоод бусдад ямар их эерэг хандлагыг төрүүлдэг, хүндлэх, энэрэх хайрлахын жишээ болдгийг илэрхийлсэн гэж дүгнэж байна.

2025/11/14-нд АӨСҮТ-ийн эмнэлгийн бусад мэргэжилтнүүдэд
-“**Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байранд мөрдөх нийтлэг журам”**Эрүүл мэнд, спортын сайдын тушаал 2015 оны 05 сарын 08 өдөр 189
**-Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023”**сэдвээр сургалт хийж 15 ажилтан хамрагдлаа.

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Ажилтнуудын хууль эрх зүй, ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх, байгууллагын дотоод журам, сахилга хариуцлагыг сайжруулах цаашдын хөдөлмөр эрхлэлтэд гарч болох эрсдлээс сэргийлэх зорилгоор ажилд шинээр томилогдсон 8, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөлөгдсөн 2, жирэмсэн амаржсаны чөлөө авсан 1 ажилтанд сургалт зөвлөгөө, мэдээлэл, чиглүүлгийг өгч ажилласан.<br>Сургалтын явцад дараах сэдвүүдийг танилцуулсан:<br>Хөдөлмөрийн тухай хууль болон Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтууд<br>Байгууллагын дотоод журам болон ажилтны эрх үүрэг, хариуцлагын талаархи мэдээлэл<br>Ажлын байрны ёс зүй, харилцаа хандлагын стандарт, байгууллагын үнэт зүйл<br>Жирэмсэний болон амаржсаны амралтын үеийн эрх зүйн зохицуулалт<br>Хүний эрх, хувийн мэдээллийн нууцлал, байгууллагын ёс зүйн зарчим | | | |
| | | Эрүүл мэндийн сайдын 2025 оны “ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙГ ҮЛ ТЭВЧИХ СЭТГЭЛГЭЭГ ХЭВШҮҮЛЬЕ” сэдэвт аяныг Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/402 дугаар тушаалаар баталсан “Ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээг хэвшүүлье” сэдэвт аяны хүрээнд АӨСҮТ-ийн хэмжээнд ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээ, шударга байдлыг эрхэмлэх аяныг 11 сарын 13-наас 2 сарын хугацаатай зохион байгуулж байна. | | | |
| 4 | Эвлэрүүлэн зуучилсан тохиолдлын тоо<br>/ 1 / | Эмч, үйлчлүүлэгчийн хооронд | Эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгчийн хооронд | Эмч, эмнэлгийн мэргэжилтний хооронд | Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, удирдлагын хооронд |
| | | / - / | / 1/ | / - / | / - / |
| 5 | Цахим хуудасны мэдээллийг баяжуулсан байдал | АӨСҮТ-д явагдаж буй үйл ажиллагаа, сургалтууд болон эрүүл мэндийн боловсрол олгох мэдээллүүдийг derma.gov.mn веб хуудас, фейсбүүк пейж хуудсаар тасралтгүй хүргэж байна. | | | |

| | |
|---|---|
| |           |

Тайланг гаргасан: Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хорооны нарийн бичгийн дарга: Ө.Буянтогтох

Тайланг баталгаажуулсан: Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хорооны дарга: Б.Баярмаа